



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/2019

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 12.1.6, Монгол улсын их сургуулийн дүрмийн 4.3.8.4, 4.3.8.8 дахь заалт, Захиргааны зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү журмыг 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын элсэлтээс эхлэн мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутан хариуцсан дэд захирал /Б.Очирхуяг/, Элсэлт, бүртгэлийн хэлтсийн дарга /М.Итгэл/, Мэдээллийн технологийн газрын дарга /А.Баатарбилэг/, Бүрэлдэхүүн сургуулийн захирал /Д.Заяабаатар, Ж.Эрдэнэбулган, Ч.Энхбаяр, Н.Баатарбилэг, С.Баттулга, П.Оюунбилэг, Т.Энх-Амгалан/ нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан МУИС-ийн захирлын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/410 тоот тушаалаар батлагдсан “МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Я.ТӨМӨРБААТАР

My document.2019.TUSHAAL.

20191516



Захирлын 2019 оны 05 дугаар сарын 31-ны  
өдрийн 05 дугаар тушаалын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН МАГИСТР, ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРТ СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх элсэлтийн үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэхэд БСШУ-ны сайдын 2014 оны А/370 дугаар тушаалаар баталсан “Магистр докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам”, “МУИС-ийн Сургалтын журам” болон энэхүү журмыг (цаашид “журам” гэнэ) мөрдөнө.

1.3. МУИС-д элсэхийг хүссэн гадаадын харьяат иргэдийн асуудлыг тусгай журмаар зохицуулна.

1.4. Энэхүү журмыг МУИС-ийн салбар сургууль (Эрдэнэт, Завхан)-д нэгэн адил дагаж мөрдөнө.

### ХОЁР. НЭР ТОМЪЁО

2.1. Журмын нэр томъёо:

2.1.1. “Бүртгүүлэгч” гэж МУИС-ийн бүрэлдэхүүн/салбар сургуулийн магистр, докторын хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргагчийг,

2.1.2. “Элсэгч” гэж Элсэлтийн шалгалт өгч элсэх болзол хангасан бүртгүүлэгчийг,

2.1.3. “Бүртгэлийн нэгдсэн систем” гэж Элсэлтийн цахим бүртгэлийн мэдээллийн систем (<https://burtgel.num.edu.mn>) цахим хуудсыг,

2.1.4. “Элсэлтийн комисс” гэж элсэлтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг хэлнэ.

### ГУРАВ. ЭЛСЭЛТИЙН КОМИСС

3.1. Элсэлтийн комиссын даргаар сургалт хариуцсан дэд захирал, нарийн бичгийн даргаар элсэлт хариуцсан нэгжийн дарга, гишүүнээр ахисан түвшний сургуулийн бодлогын нэгжийн дарга, мэдээллийн технологи хариуцсан нэгжийн дарга, хөтөлбөр хариуцсан нэгжийн дарга, бүрэлдэхүүн сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгч, багш, элсэлт хариуцсан нэгжийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн нарыг МУИС-ийн захирлын тушаалаар томилно.



3.2. Энэхүү журмаар тусгагдаагүй асуудлыг Элсэлтийн комиссын хурлаар хэлэлцэж, холбогдох дүрэм журамд нийцүүлэн шийдвэрлэх болон элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагааг зохицуулна.

### ДӨРӨВ. БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА

4.1. Магистрын хөтөлбөрт бакалаврын зэрэгтэй, докторын хөтөлбөрт магистрын (судалгааны) зэрэгтэй бүртгүүлэгчийг элсүүлнэ.

4.2. Хууль Зүйн Сургуулийн магистрын хөтөлбөрт эрх зүйн бакалавр, докторын хөтөлбөрт эрх зүйн магистр (судалгааны) зэрэгтэй бүртгүүлэгчийг элсүүлнэ.

4.3. Эрх зүйн хөтөлбөрөөс бусад хөтөлбөрийн хувьд тухайн хөтөлбөрийн өмнөх шатны боловсролын зэргийг эзэмшсэн байхыг шаардахгүй.

### ТАВ. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ

5.1. Элсэлттэй холбоотой мэдээллийг <https://www.num.edu.mn>, <https://burtgel.num.edu.mn> цахим хуудаст байршуулна.

5.2. Магистр, докторын хөтөлбөрийн элсэлтийн бүртгэлийг цахим хэлбэрээр явуулах бөгөөд элсэлт авах хөтөлбөр, хэлбэр (өдөр, эчнээ, бэлтгэл), хяналтын тоог бүртгэлийн нэгдсэн системд оруулж, намрын улирлын элсэлтийг 07 дугаар сарын 15-наас 09 дүгээр сарын 10-ыг дуустал, хаврын улирлын элсэлтийг 11 дүгээр сарын 10-наас 01 дүгээр сарын 10-ыг дуустал “Бүртгэлийн нэгдсэн систем” (<https://burtgel.num.edu.mn>)–ээр явуулна.

5.3. Бүрэлдэхүүн сургуулийн саналыг үндэслэн сургалтын үйл ажиллагааг ажлын бус өдөр (бямба, ням) зохион байгуулах хэлбэрээр тухайлсан хөтөлбөрт элсэлтийг авч болно.

5.4. Элсэлт авах магистр, докторын хөтөлбөрийн хяналтын тоог бүрэлдэхүүн сургуулийн санал, сургалт хариуцсан дэд захирлын дүгнэлтийг үндэслэн МУИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулж, бүртгэлийн нэгдсэн системд байршуулна.

5.5. Элсэлтийн бүртгэл нь дараах үе шаттай явагдана. Үүнд:

5.5.1. Бүртгүүлэгч нь МУИС-ийн бүртгэлийн нэгдсэн системд шаардлагатай мэдээллийг оруулж элсэх хүсэлтээ гаргана.

5.5.2. Бүртгүүлэхдээ бүртгэлийн нэгдсэн систем дэх анкетыг бөглөж, дараах баримт бичгийг цахим хэлбэрээр хавсаргана. Үүнд:

- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичгийн хуулбар (төрсний гэрчилгээ, гадаад паспорт);
- Эзэмшсэн боловсролын диплом, түүний хавсралтын хуулбар;
- Цээж зураг

5.5.3. Хөтөлбөрийн жагсаалтаас элсэхийг хүссэн хөтөлбөрөө сонгож төлбөл зохих бүртгэлийн хураамжийг цахим хэлбэрээр төлж бүртгэлээ баталгаажуулна.

5.6. Тус журмын 5.5.2-т заасан баримт бичиг нь гадаад хэлээр бол Монгол хэлээр орчуулан, нотариатаар батлуулсан байна.

5.7. Бүртгүүлэгч хэд хэдэн хөтөлбөрт элсэн суралцах хүсэлт гаргаж болох ба бүртгүүлсэн хөтөлбөрийн тоогоор бүртгэлийн хураамжийг цахимаар төлнө.

5.8. Бүртгүүлэгч нь бүртгэлийн нэгдсэн системд өөрийн гар утасны дугаар, цахим шуудангийн хаягийг заавал бүртгүүлэх бөгөөд эдгээр мэдээллийн үнэн зөв байдлыг бүртгүүлэгч өөрөө хариуцна. Баримт бичгийг дутуу буюу буруу оруулсан тохиолдолд шалгалтад оруулахгүй.

5.9. Бүртгүүлэгч элсэлтийн шалгалтад тэнцсэн зөвхөн нэг хөтөлбөрт элсэх эрхтэй.

### ЗУРГАА. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ

6.1. Бүртгүүлэгч нь элсэх мэргэжлийн чиглэлийн дагуу шалгалт өгнө. Шалгалтын зохион байгуулалтыг Элсэлтийн комисс хариуцна.

6.2. Элсэлтийн шалгалт нь шалгуулагчийн мэдлэг, чадварыг тодорхойлохуйц агуулгатай сорилго (тест) болон эссэ, бичиг, ярилцлага зэрэг хэлбэртэй байж болно. Элсэлт хариуцсан нэгж нь тестийн сан бүрдүүлж ажиллана.

6.3. Бүртгүүлэгч нь бакалаврын зэргийн боловсролоо МУИС-д эзэмшиж 3.0 (ХЗС-ийн хувьд 3.3)-оос дээш голчтой төгссөн бол тухайн мэргэжлээрээ МУИС-ийн магистрын хөтөлбөрт шалгалтгүйгээр элсэнэ.

6.4. Шалгалтын дүнг бүртгэлийн нэгдсэн системд элсэлт хариуцсан нэгжийн мэргэжилтэн оруулна.

6.5. Шалгалт авах хугацаа, хичээлийн байр болон шалгалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэл хаагдахаас 7 хоногийн өмнө <https://burtgel.num.edu.mn> цахим хуудсанд элсэлт хариуцсан нэгжийн ахлах мэргэжилтэн байршуулна.

6.6. Шалгалтад авбал зохих нийт онооны 60-аас доошгүй хувийг авсан шалгуулагчдыг онооны дарааллаар хяналтын тоонд багтаан элсүүлнэ.

6.7. Шалгалтад 60-аас доош хувийг авсан өөр мэргэжлийн (бүртгүүлэгчийн өмнө нь эзэмшсэн бакалавр, магистрын мэргэжил нь хүсэлт гаргасан хөтөлбөрөөс өөр) шалгуулагч бэлтгэл хөтөлбөрт суралцаж болох бөгөөд хүсэлтийг Элсэлтийн комисс шийдвэрлэнэ. Бэлтгэл хөтөлбөр нь элссэн хөтөлбөрийнхөө өмнөх түвшний мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлээс 15 хүртэл багц цагийн хичээлийг судална.

6.8. Оноо тэнцсэн тохиолдолд өмнө эзэмшсэн боловсролын дипломын голч дүнг харгалзана.

6.9. Энэхүү журмын 6.7-д заасны дагуу магистр, докторын бэлтгэл хөтөлбөрт элсэн судлах багц цагаа амжилттай судалсан суралцагч үндсэн хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцана.

6.10. Шалгуулагч шалгалтын дүнг МУИС-ийн бүртгэлийн нэгдсэн системд нэвтэрч шалгана.

6.11. Бүртгүүлэгчдийг шалгалтын онооны дарааллаар жагсаах ба элсэх болзол хангасан бүртгүүлэгчдийн бүртгэлийн дугаар болон регистрийн дугаараар элсэлт хариуцсан нэгжийн мэдээллийн самбар, цахим хуудсаар албан ёсоор зарлана.



## ДОЛОО. СУРАЛЦАГЧААР БҮРТГЭХ

7.1. Элсэх болзол хангасан элсэгч нь шалгалтын дүн зарласан өдрөөс хойш ажлын 3 хоногт багтан бүрэлдэхүүн/салбар сургууль дээр өөрийн биеэр ирж бүртгүүлнэ. Бүртгүүлэхээр ирэхдээ дараах материалыг бүртгэлийн нэгдсэн системд оруулах ба битүүмжилсэн хавтсанд хийсэн байна. Үүнд:

- Бүртгэлийн нэгдсэн систем дэх суралцагчийн гэрээ болон анкетыг бөглөсөн байх (бүртгэл хариуцсан нэгжийн мэргэжилтэн хэвлэж, хавсаргах);
- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг (төрсний гэрчилгээ, гадаад паспорт), хуулбарын хамт;
- Өмнө нь эзэмшсэн боловсролын диплом, хавсралт (бакалавр болон магистрын диплом хуулбарын хамт);
- Цээж зураг нэг хувь, бүртгэлийн нэгдсэн системийн шаардлагад нийцсэн байх (сүүлийн гурван сард авахуулсан).

7.2. Бүртгэлийн мэдээллийг баримт бичгийн эх хувьтай нь шалгаж, Элсэлт хариуцсан нэгжийн тухайн сургуулийг хариуцсан бүртгэлийн мэргэжилтэнд бүртгүүлэн сургалтын мэдээллийн систем ашиглах эрхээ авна.

7.3. Элсэх болзол хангасан боловч заасан хугацаанд ирж бүртгүүлээгүй элсэгчийг элсэн суралцах эрхээсээ татгалзсан гэж үзэн тус журмын 6.8-д заасан шаардлагыг биелүүлсэн дараагийн элсэгчид элсэх эрхийг шилжүүлнэ.

7.4. Элсэгч нь "МУИС-ийн Сургалтын журам"-д заасан хичээлд бүртгүүлэн баталгаажуулах "тэг" долоо хоногт хуваарийн дагуу чиглүүлэх сургалтад хамрагдана.

## НАЙМ. БУСАД

8.1. Бүртгүүлэгч бүртгүүлэхээс өмнө энэхүү журамтай танилцах үүрэгтэй.

8.2. Бүртгүүлэгчийг хүсэлт гаргасан хөтөлбөрөөс өөр хөтөлбөрт шилжүүлэн элсүүлэхгүй.

8.3. Бүртгүүлэгч системд бүртгүүлсэн боловч МУИС-ийн үйл ажиллагаанаас үл хамааран элсэлтийн шалгалтыг өгөөгүй бол бүртгэлийн хураамжийг буцааж олгохгүй.

8.4. Элсэлттэй холбоотой баримт бичгийг хуурамчаар үйлдвэл МУИС-д элсүүлэхгүй бөгөөд хуурамч бичиг баримтаар элссэн нь тогтоогдсон тохиолдолд сургуулиас хасна.

\*

\*

\*